



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 2/65

Улаанбаатар хот

**Б.Цэндээгийн хөдөлмөр эрхлэлтийн
харилцааг цуцлах, ажлаас чөлөөлөх, тэтгэмж
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.1.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 24 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн №03 дугаар хуралдаанаар зөвшилцсөн шийдвэр, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, 9.9.8 дахь заалт, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 5.17 дахь хэсэг, Гүйцэтгэх захирлын 2022 оны Б/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, хангамжийн асуудал эрхэлсэн Дэд захирлын ажлын байр хасагдсантай холбогдуулан Баянжавын Цэндээгийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон цуцалж, ажлаас чөлөөлсүгэй.

2. Санхүү, хангамжийн асуудал эрхэлсэн Дэд захирлын ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Ө.Удвал

(Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Н.Нэргүй

(Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч)

Э.Наранбаатар

(Бараа, материалын нягтлан бодогч)

3. Ажлыг 2022 оны 03 дугаар сарын 31-ний дотор актаар хүлээлцүүлж, баримтыг Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсэг (Ө.Удвал)-т үүрэг болгосугай.

4. Б.Цэндээд 4 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгох, холбогдох тооцоог хийж, дуусгахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ